



“ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Я.БАТСУУРЬ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.28 № 1/19

Зөрчил арилгуулах тухай


“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх явцад түлш болон тос тосолгооны материалын зарцуулалт, үнэлгээг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Уурхайн зарим төрлийн машин механизм, тоног төхөөрөмж хуучирч эвдэрсэн тул спидометрийн заалт нь ажиллахгүй болсон, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ажилласан мото цагийн бүртгэлийг хөтөлж байгаа боловч түлшний зарцуулалтад бус, зөвхөн уулын ажлын хөдөлмөрийн бүтээмжийг тодорхойлоход ашиглаж байна. Энэ нь машин тоног төхөөрөмжийн марк, нэр төрөл тус бүрээр нэгжийн норм норматив баталж мөрдөөгүйгээс хөрөнгө үргүй зарцуулагдах, улмаар компанийн үр ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 27 дугаар тушаалаар түлш, шатахуун, тослох материалын норм зохиох ажлын хэсгийг байгуулж судалгаа хийж байгаа боловч одоогоор баталгаажуулсан шийдвэр гараагүй байна.
- “Эрдэнэс Таван толгой” ХК нь “Ти Ти Жи Ви Си Θү” ХХК-тай 2011 оны 10 сарын 13-наас гэрээ байгуулж гэрээний дагуу тус компаниас тос, тосолгооны материалыг нийлуулдэг бөгөөд орлого зарлагын анхан шатны баримтыг цаг хугацаанд нь егдэггүй, баримтын тоо хэмжээ, өртөг тодорхой бус байгаа нь НББ-ийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7-д заасан анхан шатны баримт бүрдлийг зөрничж байна.
- Мөн уурхайн тос тосолгооны материалыг нарийн хэмжих хэмжүүр байхгүйгээс нүдэн баримжаагаар хэмжилт хийдэг бөгөөд дээрх компаний нэхэмжилсэн дүнгээр зардлыг тооцож, түүний хадгалалт хамгаалалтад тавих хяналт сүл байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмыг 3.1.1-д заасныг үндэслэн АЛБАН ШААРДЛАГА өгч байна.

1. Гэрээт олборлогч “Ти Ти Жи Ви Си Θү” ХХК-тай хамтран түлш, шатахууны норм нормативыг боловсруулж, машин тоног төхөөрөмж нэг бүрээр тогтоон шийдвэрийг гаргаж, түүнд тавих хяналтыг сайжруулах.
2. Тос тосолгооны материалын орлого зарлагын баримтыг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлж, бүртгэлд тусган, түүний зарцуулалт болон хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг чангатгах талаар арга хэмжээ авч түүний үр дүнг 2014 оны 7 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

Чанарын баталгаажуулалтын
менежер



Ц.Сугармаа